



БАТЛАВ:
“НЬЮ СИТИ ПРИНТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Д.ТӨГСГЭРЭЛ


БАТЛАВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.НАРАНТУЯА


ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар № 17/12-01

Улаанбаатар хот

2017 12 18 177

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Нэг талаас “ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” /цаашид захиалагч гэх/ нөгөө талаас “НЬЮ СИТИ ПРИНТ” ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/ нар харилцан тохиролцсоны үндсэн дээр хамтран ажиллах гэрээг байгуулав.

1.2 Энэхүү гэрээний зорилго нь

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Эмнэлэгт нянгийн эсрэг эмийн хэрэглээг оновчтой төлөвшүүлэх ” гарын авлага	50	8000	400,000₮
2	Зайлшгүй шаардалагатай эмийн жагсаалт	1000	2600	2,600,000₮
	Нийт			3,000,000₮

хэвлэх ажлыг зохицуулахад оршино.

1.3 Дээрх хэвлэлүүдийг чанарын өндөр түвшинд хэвлэж, захиалагч талд хүлээлгэн өгнө.

1.4 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

ХОЁР. Захиалагчийн эрх үүрэг

2.1 Захиалагч бүрэн гүйцэтгэгдсэн хэвлэлийн эхийг чанарын өндөр түвшинд бэлдэж, файлаар өгнө.

2.2 Захиалагч тал эх загварын алдааг шалгасны эцэст хэвлэх зөвшөөрөл олгон гарын үсэг зурж, баталгаажуулна.

2.3 Захиалагч тал баталсан эх загвар дээрх алдааг бүрэн хариуцна.

2.4 Захиалгат ажлыг гүйцэтгэх явцад захиалагчийн зүгээс хянах, зөвлөх үүрэг хариуцлага бүхий хүнийг ажиллууна.

2.5 Гэрээнд тусгагдсан хугацаанд төлбөрийг хийж гүйцэтгэнэ.

2.6 Хэрэв захиалагчаас үүдэлтэй шалтгаанаар бүтээгдэхүүнийг ажлын бус цагаар хүлээн авах шаардлагатай болсон бол захиалагч өөрсдийн унаагаар очиж авна.

ГУРАВ. Гүйцэтгэгчийн эрх үүрэг

3.1 Гүйцэтгэгч тал Захиалагч талыг эх загвараа баталгаажуулж, гарын үсэг зурсны дараа баталсан загварын дагуу чанарын өндөр түвшинд хэвлэнэ.

3.2 Захиалгат ажлыг тогтоосон хугацаанд бэлэн болгож, ажлын цагаар хүргэж өгнө.

3.3 Гэрээнд заагдсан тооноос илүү хэвлэх, захиалагчтай тохиролцоогүйгээр дахин хэвлэхийг хориглоно.

3.4 Захиалагчийн баталсан загвар нь алдаатай байсан өөрөөр хэлбэл захиалагчаас шалтгаалсан нь хэвлэгдсэний дараа илэрсэн тохиолдолд үүнээс үүдэн гарах хохиролыг гүйцэтгэгч хариуцахгүй.

3.5 Гүйцэтгэлийн явцад захиалагчийн баталсан загвар дээр байхгүй шинээр нэмж алдаа гаргасан нь тогтоогдсон тохиолдолд гүйцэтгэгч хариуцна.

3.6 Бэлэн болох хугацааг загвар баталснаас хойш бүтээгдэхүүний онцлогийг харгалзан тогтоосон хугацаанд бэлэн болгоно.

3.7 Гүйцэтгэгч нь захиалсан хэвлэмэл бүтээгдэхүүнийг тохиролцсон хугацаа, захиалсан өгөгдөл, тоо ширхэгийн дагуу захиалагч талд хүлээлгэн өгөх үүрэгтэй.

3.8 Гүйцэтгэсэн ажлыг актаар хүлээлцэх үед гүйцэтгэгчийн буруугаас үүссэн аливаа гологдол, доголдлыг 5 хоногийн дотор өөрийн зардлаар дахин хийж гүйцэтгэнэ.

3.9 Гүйцэтгэгч нь гэрээ байгуулсан захиалагчыг ямар нэгэн хүндрэл чирэгдэл үүсгэхгүйгээр үйлчлэх үүрэгтэй бөгөөд оргил ачааллын үед компанийн хүрээнд аль болох хурдан шуурхай зохицуулах үүрэг хүлээнэ.

ДӨРӨВ. Талуудын хариуцлага

4.1 Гүйцэтгэгч тал хэвлэлийн чанарын гологдол гаргасан тохиолдолд захиалагч талыг хохиролгүй болгоно.

ТАВ. Төлбөр тооцоо

5.1 Энэхүү гэрээний хүрээнд хийгдэх ажлуудын төлбөр **3,000,000₮** (гурван сая төгрөг) байна.

5.2 Захиалагч тал нь бүтээгдэхүүний төлбөрийг **“Төрийн банк” 109500002389** тоот дансанд нэхэмжлэхээр шилжүүлнэ.

5.3 Шаардлагатай тохиолдолд хэвлэлийн ажлын материалын зардлыг шилжүүлсэний дараа ажлыг гүйцэтгэж эхлэнэ.

ЗУРГАА. Бусад зүйл

6.1 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчинтэй болох бөгөөд энэхүү гэрээний салшгүй хэсэг нь байна.

6.2 Талууд энэхүү гэрээгээр тодорхойлсон үүргээ гүйцэтгээгүйгээс нөгөө талдаа учирсан хохирлыг бүрэн хариуцаж, арилгана.

6.3 Гэрээний явцад гарсан маргаантай асуудлыг хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэх ба тохиролцохгүй тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

6.4 Энэхүү гэрээг 2% үйлдэх бөгөөд тус бүр хүчин төгөлдөр болно.

Гэрээ байгуулсан:

ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛ:

“НЬЮ СИТИ ПРИНТ” ХХК-ийн
Ерөнхий менежер


П. Бат - Өлзий
ХТА2727 @ 6390203

ЗАХИАЛАГЧ ТАЛ:

ЭМХТ Эм, өмнэлгийн
хэрэгслийн албаны дарга


Г.Цэцэнсанаа
ХХА0456 9086331